



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 58

Мөрөн

**Орон нутгийн өмчийн төлөөлөл
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн "н, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. " Могойн гол" хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд орон нутгийн өмчийн төлөөллийг дараах бүрэлдэхүүнтэй томилж, удирдамжийг хавсралтаар баталсугай.

- Ц.Бэхбаяр - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
- Ц.Баттогтох – Төрийн банкны гүйцэтгэх захирал
- Ж.Жавзанпагма – Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын дэд дарга
- Г.Төмөрбаатар - Аймгийн Ахмадын хорооны дарга

2. Орон нутгийн өмчийн төлөөллийн бүрэлдэхүүнийг мэргэжил аргазүй, удирдлагаар хангаж, үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Цогтоо/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

010274

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны
04 дүгээр сарын 12-ны өдрийн 58 дугаар



**"МОГОЙН ГОЛ" ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн хуралд оролцох орон нутгийн
өмчийн төлөөлөгчдийн удирдамж**

"Могойн гол" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн анхдугаар хуралд Хөвсгөл аймгийн өмчийн төлөөлөл болон томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах удирдамжийн дагуу оролцоно.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад Ц.Баттогтохыг нэр дэвшүүлж, саналаа өгнө.

_____ оОо _____